

УДИРДАМЖ

“UB DRONE BATTLE” УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

2025 оны 09 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

I.ЗОРИЛГО:

Нийслэлийн оюунлаг, соёлтой, ухамсарт иргэнийг төлөвшүүлэх, эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, инновац, шинэчлэлийн үнэт зүйлсийг дэмжих, Улаанбаатар хотыг оюунлаг иргэншил, өв уламжлал ба ногоон хөгжил, орчин үеийн зохицол бүхий жишиг хот болгох, уран бүтээлчдийн туршлага солилцох боломжийг бүрдүүлэх.

II. ЗОРИЛТ

Улаанбаатар хотын хөгжил, бүтээн байгуулалт, архитектур, байгаль орчны өөрчлөлтийг эерэг өнцгөөс олон нийтэд таниулах, иргэний соёлын боловсрол, оюунлаг иргэншил, хамтаар орших ухамсрыг бүтээлч байдлаар илэрхийлэх, хотын үнэт зүйлс болох оюунлаг соёл, ногоон хөгжил, өв уламжлал ба орчин үеийн зохицлыг бүтээлчээр харуулах, дэвшилтэт технологи, дижитал урлагийн шинэлэг хэрэглээг хөгжүүлж, инновацийн соёлыг төлөвшүүлэн Улаанбаатар хотын нэр хүндийг олон улсад сурталчлах

III. ХАМРАХ ХҮРЭЭ

- Уралдаанд бүх насны, мэргэжлийн болон мэргэжил харгалзахгүй иргэд оролцох боломжтой.

IV. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Видео контент:

- Хугацаа: 15 секундээс 2 минут хүртэл
- Улаанбаатар хотын орчин үеийн дүр төрх, иргэдийн амьдралын хэв маяг, соёлын боловсрол, байгаль орчин, хотын соёл, хамтаар амьдрах нийгмийн сайн сайханд үлгэр үзүүлэх үнэт зарчмыг түгээн дэлгэрүүлэх агуулгыг харуулсан байх
- Оюуны өмчийн хуулийг дээдэлсэн байх
- Бүтээлийн агуулга, чанар, бүтээлч хандлага, шинэ шийдэл, уран сэтгэмжийг харж үнэлнэ.
- Дуу, дүрсний зохицол, эвлүүлэг, өнгө, өгүүлэмжийн чанар өндөр түвшинд байх

Техникийн шаардлага:

- Камер, гар утас, дрон, олон үйлдлийн камер зэрэг бүх төрлийн төхөөрөмж ашиглаж болно
- Видео: HD (1280x720) болон түүнээс дээш чанартай
- Бүтээл нь шинэлэг, эх загвар байх ёстой (хуулбар болон AI-гаар бүрэн бүтээсэн байж болохгүй)

V. ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

- Бүтээлийг wetransfer линкээр ub.drone.battle@ulaanbaatar.mn цахим хаягаар хүлээж авна
- Бүтээлүүдийг “UB Drone Battle” албан ёсны Facebook болон Instagram хуудсанд нийтэлнэ
- Хуурамч, зохиомол хандалт илэрвэл оноо хасалт хийнэ
- Урьдчилсан шат – Олон нийтийн оролцоо Like, Share, Comment зэргийн тоо: 20 оноо
- Эцсийн шат – Шүүгчдийн үнэлгээ (80%)
- Агуулгын зохиомж: 20 оноо
- Бүтээлч санаачлага, шинэ шийдэл: 25 оноо

- Техникийн дуу, дүрсний гүйцэтгэл: 20 оноо
- Нийгмийн эерэг уриалга: 15 оноо
- Нийт үнэлгээ: 100 оноо
- Хэрэв оноо тэнцвэл ерөнхий шүүгчид зөвлөлдөж шийднэ.

VI. УРАЛДААНЫ ХУГАЦАА

- Уралдааны бүтээл хүлээн авах, бүтээлийг олон нийтэд түгээх: 2025 оны 09 дүгээр сарын 10–ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдөр (бүтээл хүлээн авах хугацааг оролцогчдын хүсэлтээр 10 хоногоор сунгасан болно)
- Уралдааны шалгаруулалт хийх: 2025 оны 10 дугаар сарын 13-17-ны өдөр
- Шилдэг бүтээлийн шагнал гардуулах: 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

VII. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

- 1 дүгээр байр: DJI Mavic Pro 4 (мэргэжлийн дрон)
- 2 дугаар байр: 10,000,000 төгрөг (мөнгөн шагнал)
- 3 дугаар байр: 5,000,000 төгрөг (мөнгөн шагнал)

VIII. ХОЛБОО БАРИХ

- И-мэйл: ub.drone.battle@ulaanbaatar.mn
- Facebook/Instagram: @ubdronebattle <https://www.facebook.com/ub.drone.battle>, https://www.instagram.com/ub.drone.battle?igsh=cmlqM2Jsb2Nrd3Vz&utm_source=qr

Холбоо барих: Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын үйлдвэрлэл, урлагийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Шашу (95879597), мэргэжилтэн М.Цэрэнтогтох (88101517)